



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 10 сарын 08 өдөр

Дугаар 338


Улаанбаатар хот

“Үндэсний хөрөнгө оруулалтын банк” ХХК-д
даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1, 15.3.3, Банкны тухай хуулийн 6.2.3, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5.1.2, 11.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 61 дүгээр тогтоол “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 2.39 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үндэсний хөрөнгө оруулалтын банк” ХХК-д даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай.
2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж, даатгагч болон даатгуулагчийн хууль ёсны эрх ашгийг дээдлэн ажиллахыг “Үндэсний хөрөнгө оруулалтын банк” ХХК /П.Даваа/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д. БАЯРСАЙХАН